**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хот

<table>
<tr><th>Д\Д</th><th>Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</th><th>Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан</th><th>Цаашид авч хэрэгжүүлэх арга зам</th><th>Оноо</th></tr>
<tr><td colspan="5">Үүрэг, даалгавар НЭГ: Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн, нэгж байгууллагууд хуваарийн дагуу хог, хаягдлыг ачуулах болон хог, хаягдлыг тээвэрлэх ажлын явцад газар дээр нь хяналт тавих, танилцуулах.</td></tr>
<tr><td>1.</td><td>Дүүргийн хэмжээнд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж байгууллагуудыг өдрийн цагаар ил задгай хог хаяхгүй байх, шөнийн тээвэрлэлтийн цагаар хог, хаягдлаа битүүмжлэн гаргаж ачуулах ажил дээр Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран шаардлага тавьж ажиллаж байна.<br></td><td>=</td><td>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.</td><td>70%</td></tr>
<tr><td colspan="5">Үүрэг, даалгавар ХОЁР: Инженерийн хангамжийн байгууллагуудад ямар мэргэжлийн, ямар туршлагатай, хэдэн инженер хэрэгцээтэй байгаа талаар тоон мэдээллийг гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт ирүүлэх.</td></tr>
<tr><td>2.</td><td>Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн чиг үүргийн хүрээнд дараах мэргэжлийн инженер, техникийн ажилтнууд шаардлагатай байна. Үүнд:</td><td>=</td><td>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Авто зам, гүүрийн инженер /1-3 жилийн ажлын туршлагатай/ - 1<br>Усны барилга байгууламжийн инженер /1-3 жилийн ажлын туршлагатай/ -1<br>Барилгын инженер /1-3 жилийн ажлын туршлагатай/ -1<br>Цахилгааны инженер /1-3 жилийн ажлын туршлагатай/ - 1<br>Сангийн инженер /1-3 жилийн ажлын туршлагатай/ -1<br>Барилгын чанарын инженер /1-3 жилийн ажлын туршлагатай/ -1 саналыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын Ахлах мэргэжилтэн Б.Амирлангийн https://erp.ulaanbaatar.mn хаягаар хүргүүлж ажилласан. | | | |
| **Үүрэг, даалгавар ГУРАВ:** Усан оргилууруудыг ажилд оруулах болон нийтийн эзэмшлийн талбайг цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | |
| 3. | Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний ажлуудын гудамж зам талбайн хөшөө дурсгал, усан оргилуур, сандал, хогийн сав бичил цэцэрлэг зэрэг эд хөрөнгүүдийн цэвэрлэгээ, угаалга, засвар үйлчилгээний төлөвлөгөө гарган Чингэлтэй дүүргийн Тохижилт Үйлчилгээ ХХК-тай дүүргийн өмчийн хамгаалалтын ажлын гэрээ байгуулан шат дараалалтайгаар хийж гүйцэтгэхээр засварын ажлыг эхлүүлээд байна. Дүүргийн хэмжээнд нийт 8 усан оргилуур байгаа бөгөөд засварын ажлыг дуусган 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлэн ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбайн 5 байршилд 7000 цэцэг тарихаар бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>       | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана. | 70% |
| НИЙТ | | | | 72% |